

Есүс Христийн Хоёр дахь ирэлт хэзээ тохиох вэ?

ШИНЭ ГЭРЭЭНИЙ СЕМИНАРЫН ГАРЫН АВЛАГА

Та Есүс Христийн Хоёр дахь ирэлт хэзээ тохиох тал дээр эсвэл үүнд бэлтгэлтэй байж чадах эсэх талаараа хэзээ нэгэн цагт эргэлзэж байсан уу? Тесалоникийн гэгээнтнүүдэд ч гэсэн ийм асуулт байсан байх.

1 Тесалоник 5:1–3-ыг уншаад, Есүсийн дэлхийд эргэж ирэх цаг хугацааг дүрслэхдээ Паулын ашигласан зүйрлэлийг хайж ол.

- Та юу олж мэдсэн бэ?
- Шөнийн хулгайч, төрөхийн өвдөлт нь эхэлсэн жирэмсэн эмэгтэй нарын талаарх Паулын зүйрлэл танд Аврагчийн Хоёр дахь ирэлтийн талаар юу зааж байна вэ?

1 Тесалоник 5:4–6-г уншаад, Хоёр дахь ирэлтэд бэлтгэх талаарх Паулын заасан үнэнүүдийг олж мэд. Эдгээр сургаалыг Сургаал ба Гэрээ 106:4–5-тай харьцуул.

- Та ямар ойлголт олж авсан бэ?

Паулын сургаалаас бидний олж мэдэж болох нэг үнэн бол **хэрэв бид Есүс Христийг дагах замаар “гэрлийн хүүхдүүд” болохоор чармайх юм бол бид Түүнийг дахин ирэхэд бэлтгэгдсэн байх болно.**

Их Эзэн биднийг гэрлийн хүүхдүүд болоход ямар арга замуудаар урьдаг болох талаар судлахын тулд 3 Нифай 18:24; Сургаал ба Гэрээ 50:23–25; 88:67–68-ыг уншина уу. Хэрхэн гэрлийн хүүхэд болох талаар ойлгоход тань туслах олж мэдсэн зүйлсээ судлах тэмдэглэлдээ жагсаан бич.

- Та Их Эзэний гэрлийг өөрийн амьдралд хэрхэн урьж байна вэ? Та Их Эзэний гэрлийг өөрийн амьдралд хэрхэн илүү их урих вэ?